

Булган аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтэс 2019 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/116/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2020 он

Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 90900910

Цахим хаяг:

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 99057478

Цахим хаяг:

Аудитор:

Г.Намчинсүрэн

«Audit_name» Булган аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Утас: 91995689

Цахим хаяг: Namchinsuren999@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	4
2	Аудитын тайлан	6
2.1	Оршил	6
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	7
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	7
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	8
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал..... Error! Bookmark not defined.	
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... Error! Bookmark not defined.	
2.11.	Шилэн дансны мэдээлэл	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3	Менежментийн захидал	13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	14

1 Аудитын гэрчилгээ

		Г ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ДАРГА, ДЭД ХУРАНДАА Д.ТӨГСБАЯР ТАНАА
БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР		
63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг, Утас: 7034-2580, Факс: 7034-2580		
2020.02.06 № 32		
Танай _____	-ны № _____	Т _____
Аудитын гэрчилгээ		
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>		
Зөрчилгүй санал дүгнэлт		
<p>Булган аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>		
Санал дүгнэлтийн үндэслэл		
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>		
<p>Аудитаар Булган аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын Булган аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>		
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>		
		006020061

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.АНХБАЯР

2 Аудитын тайлан

2.1. Оршил

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Булган аймаг дахь ШШГ-ын дарга Төгсбаяр-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн тайлагнал, зардлын данстай холбоотой холбогдох дүрэм журмыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 29-нөөс 2020 оны 01 дүгээр сарын 31-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 01 дүгээр сарын 31-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймгийн аудитын газар-ын Г.Намчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Булган аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймгийн аудитын газар-т 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр-ны өдрийн 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Байгууллагын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Булган аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэж, цагдан хорих, баривчлах болон хорих ял эдлүүлэх үйл ажиллагааг олон улсын жишгийн түвшинд хуулийн хүрээнд зохион байгуулах, эд хөрөнгийн холбогдолтой шийдвэр бүрийн биелэлтийг хангах, үйлчлүүлэгч, хэрэглэгчид шуурхай үйлчлэхэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Булган аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа
- Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа
- Цагдан хорих

Булган аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцэж байна.

санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахгүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Булган аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “UNICUS” программ хангамж ашигладаг байна.

Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 26 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 0 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 2 хувиар сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 299055.1 мянган төгрөгөөс тооцон 5981.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардлын 2 хувь буюу 11777.8 мянган төгрөгөөр тооцсон нь байгууллагын нийт болон цэвэр хөрөнгөөс материаллаг түвшинг тогтооход материаллаг байдлын түвшин хэт өндөр гарч байгаатай холбоотой болно. /

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 26 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 20 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

2.9. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Булган аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40462.2 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Хүснэгт 1. /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	
Авлага	4621.88	0	4621.88
Урьдчилгаа	0	0	
Бараа материал	52,422,145.63	48,619,815.05	3,802,330.58
Үндсэн хөрөнгө	1,333,956,064.29	1,297,296,106.24	36,659,958.05
Нийт хөрөнгө	1,386,378,209.92	1,345,915,921.29	40,462,288.63
Өр төлбөр	0	0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,386,378,209.92	1,345,915,921.29	40,462,288.63

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,386,378,209.92	1,345,915,921.29	40,462,288.63
---	------------------	------------------	---------------

Авлага дансны үлдэгдэл 4,621.88 буурсан. Авлага дансны үлдэгдэлд 2018 онд үүссэн, тайланд онд бүрэн барагдсан.

Бараа материалын дансны үлдэгдэл 3802.3 мянган төгрөгөөр буурсан нь бараа материал акталж устгасан, тайлант оны зарцуулалтаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 48619.8 мянган төгрөг байгаагаас 2019 онд худалдаж авсан бараа материалыг бүрэн зарцуулсан байна. Ашиглалтгүй 162.4 мянган төгрөгийн бичиг хэргийн бараа материал байна. Энэ нь оны эцэст харьяа дээд байгууллагаас үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авсан орлого нь зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансанд 2018-2019 оны хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгөнөөс харьяа байгууллага болон харилцагч байгууллагад шилжүүлсэн хөрөнгө байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 36659.9 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө акталсан болон хуримлагдсан үр дүнгээс шалтгаалжээ. Хөрөнгө оруулалт тайлант онд байхгүй, үнэ төлбөргүй хүлээн авсан 6557.2 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн байхгүй, акталсан 18100.0 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1345915.2 мянган төгрөг болж 40462.3 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө акталсан болон хуримтлагдсан үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь санхүүгийн байдлын тайланд нөлөөлөх үр дагаваргүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга бичилт байхгүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Булган аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар тайлант онд 1210.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1210.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого төгрөг/

/мянган

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мал аж ахуйн түүхийн эдийн орлого	1,210,600	1,210,600	0	100
Нийт дүн	1,210,600	1,210,600	0	100

Давсан болон тасарсан орлого байхгүй дотоод орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 535611.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 535611.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 534401.0 мянган төгрөгийг улсын /орон нутгаас/ төсвөөс, 1210.6 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тайлант онд хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ төлөвлөгдөөгүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 535141.4 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь нийт 470.1 мянган төгрөгийг хэмнэж төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Засаг даргын нөөц хөрөнгөөс 2500.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: 2500.0 мянган төгрөгийг урсгал засварын зардалд тусгуулан, автомашины сэлбэг хэрэгсэлд зарцуулж, бараа материалын тайланд тусгасан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 26 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 20 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар нийт 5704.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 5704.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Булган аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Нийт 4187.2 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг нягтлан бодох бүртгэл тайланд тусгахдаа бусад үндсэн хөрөнгө дансанд бүртгэж буруу ангилж тайлагнасан.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

1.3. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн ангиллын залруулга хийж, УСННБОУС-ын холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

2. Зардал данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бараа ажил үйлчилгээний зардлаас 474.5, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 260.5, нийт 735.0 мянган төгрөгийг бүлэг хооронд шилжүүлэх зарцуулсан нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5.5 дахь заалт, сангийн сайдын 2015 оны 01 дүгээр 20-ны өдрийн 7-р тушаалыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй.

2.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох дүрэм журам зөрчигдөх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5.5 дахь заалт, сангийн сайдын 2015 оны 01 дүгээр 20-ны өдрийн 7-р тушаалыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

3. Зардал данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Хот дотор ажил үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см³-ээс дээш автомашин хэрэглэн нийт 782.2 мянган төгрөгийг үргүй зарцуулсан байна.

3.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох дүрэм журам зөрчигдөх.

3.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11-д: “төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах”, Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын хавсралт 2-д заасан заалтыг мөрдөж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/Төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>52422145.63</u>	<u>48619815.05</u>
33	АВЛАГА	4621.88	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4621.88	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	52417523.75	48619815.05
351	Түүхий эд материал	21662354.30	19411892.30
35110	Тусгай зориулалттай материал	21364223.10	19140123.10
35130	Эм боох материал	298131.20	271769.20
35300	Бэлэн бүтээгдэхүүн	0.00	977162.00
354	Хангамжийн материал	26015169.45	23070760.75
35410	Бичиг хэргийн материал	284832.00	162420.00

«Audit_name» Булган аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

35420	Аж ахуйн материал	17157779.10	14095765.60
35440	Түлш, шатах тослох материал	571480.00	61480.00
35450	Барилгын засварын материал	2181322.35	1275029.15
35460	Хүнсний материал	5819756.00	7476066.00
35600	Мал амьтад	4740000.00	5160000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1333956064.29</u>	<u>1297296106.24</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1333956064.29	1297296106.24
392	Биет хөрөнгө	1088594064.29	1051934106.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	996476386.49	996476386.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	-609166.38	-22075945.26
39203	Авто-тээврийн хэрэгсэл	165486825.00	147386825.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-103861824.57	-98553491.46
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	66854329.20	73411619.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-44279131.92	-51275986.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19009126.00	19009126.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17589492.28	-18374863.50
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	3700000.00	3700000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	6417692.31	6417692.31
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3010679.56	-4187256.50
393	Биет бус хөрөнгө	245362000.00	245362000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	245362000.00	245362000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1386378209.92</u>	<u>1345915921.29</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1386378209.92</u>	<u>1345915921.29</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1386378209.92	1345915921.29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	337072727.16	337072727.16
51101	Өмч: - төрийн	337072727.16	337072727.16
512	Хуримтлагдсан үр дүн	700905240.48	660442951.85
51210	Өмнөх үеийн үр дүн	700905240.48	700905240.48
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-40462288.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	348400242.28	348400242.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1386378209.92</u>	<u>1345915921.29</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	484191119.88	548431831.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7464719.88	11530831.00
120	Нийтлэг татварын бус орлого	7464719.88	11530831.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7464719.88	11530831.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4621.88	1210600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7460098.00	10320231.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	476726400.00	536901000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	469726400.00	534401000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	469726400.00	534401000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7000000.00	2500000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7000000.00	2500000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	520159732.99	588894119.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	520159732.99	588894119.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	517012144.91	587123983.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	319009191.10	383638098.90
210101	Үндсэн цалин	233763266.87	259453059.13
210102	Нэмэгдэл	85245924.23	124185039.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5874596.92	7492073.16
210205	Эрүүл мэндийн даатгал	5874596.92	7492073.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79121000.00	79130000.00
210301	Гэрэл, цахилгаан	4550908.00	6267659.87
210302	Түлш, халаалт	69221000.00	69220800.00
210303	Цэвэр, бохир ус	5349092.00	3641540.13
2104	Хангамж, бараа материалын зардал	25015558.00	21489012.00
210401	Бичиг хэрэг	4594616.00	1352132.00
210402	Тээвэр, шатахуун	14604015.00	13212004.84
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4029177.00	1830395.16
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	168000.00	133500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	929750.00	788980.00
210408	Бараа материал акталсны зардал	690000.00	4172000.00
2105	Нормативт зардал	31747053.40	31602044.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	980600.40	833492.00
210502	Хоол, хүнс	27570204.10	28446560.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3196248.90	2321992.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9544325.92	13641393.20
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	89500.00
210604	Урсгал засвар	9544325.92	13551893.20
2107	Томилолт, зочны зардал	2000000.00	1240000.00
210702	Дотоод албан томилолт	2000000.00	1240000.00

«Audit_name» Булган аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3096588.00	4014582.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1188900.00	1960000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	527188.00	514088.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165000.00	143000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	954500.00	954500.00
210807	Газрын төлбөр	261000.00	442994.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41603831.57	44876780.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800000.00	1167032.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	492500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40803831.57	43217248.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3147588.08	1770135.82
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	259200.00	300000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	259200.00	300000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1000000.00	1000000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1000000.00	1000000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1888388.08	470135.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1888388.08	470135.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-35968613.11	-40462288.63
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-35968613.11	-40462288.63

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	476090312.86	537881464.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1252300.94	1450600.00
120	Нийтлэг татварын бус орлого	1252300.94	1450600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1252300.94	1450600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1252300.94	1450600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	474838011.92	536430864.18
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	467838011.92	533930864.18
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	467838011.92	533930864.18
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7000000.00	2500000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7000000.00	2500000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	476090312.86	537881464.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	476090312.86	537881464.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	473577969.62	536581464.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	319024963.22	382264623.60

«Audit_name» Булган аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210101	Үндсэн цалин	213392977.41	247215843.24
210102	Нэмэгдэл	105631985.81	135048780.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7237418.40	8860926.58
210201	Тэтгэврийн даатгал	1917900.90	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5319517.50	8860926.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79121000.00	79130000.00
210301	Гэрэл, цахилгаан	4550908.00	6267659.87
210302	Түлш, халаалт	69221000.00	69220800.00
210303	Цэвэр, бохир ус	5349092.00	3641540.13
2104	Хангамж, бараа материалын зардал	24342000.00	16830300.00
210401	Бичиг хэрэг	3956133.00	1067300.00
210402	Тээвэр, шатахуун	15726492.00	13092004.84
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2876975.00	1830395.16
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	168000.00	133500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1614400.00	707100.00
2105	Нормативт зардал	24900000.00	29600000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5856687.00	807130.00
210502	Хоол, хүнс	19043313.00	28792870.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11100000.00	12810600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1069900.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	516500.00	89500.00
210604	Урсгал засвар	9513600.00	12721100.00
2107	Томилолт, зочны зардал	2000000.00	1240000.00
210702	Дотоод албан томилолт	2000000.00	1240000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5052588.00	4254582.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2520000.00	2200000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	504900.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	527188.00	514088.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165000.00	143000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	954500.00	954500.00
210807	Газрын төлбөр	261000.00	442994.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	800000.00	1590432.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800000.00	1097932.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	492500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2512343.24	1300000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	260042.30	300000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	260042.30	300000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1000000.00	1000000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1000000.00	1000000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1252300.94	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1252300.94	0.00

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бу сад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,710,727.16	0.00	701,479,282.05		793,190,009.21
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	245,362,000.00	0.00	0.00		245,362,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	337,072,727.16	0.00	701,479,282.05	0.00	1,038,552,009.21
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	348,400,242.28	0.00		348,400,242.28
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00		0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-574,041.57		-574,041.57
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,072,727.16	348,400,242.28	700,905,240.48	0.00	1,386,378,209.92
D01	2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	337,072,727.16	348,400,242.28	700,905,240.48	0.00	1,386,378,209.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00		0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	337,072,727.16	348,400,242.28	700,905,240.48	0.00	1,386,378,209.92
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00		0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00		0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-40,462,288.63		-40,462,288.63
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,072,727.16	348,400,242.28	660,442,951.85	0.00	1,345,915,921.29

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	538111600.00	537881464.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	538111600.00	537881464.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	536811600.00	536581464.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	382287200.00	382264623.60
210101	Үндсэн цалин	240681400.00	247215843.24
210102	Нэмэгдэл	138605800.00	135048780.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2000000.00	0.00
210104	Урамшуулал	1000000.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9072700.00	8860926.58
210205	Эрүүл мэндийн даатгал	9072700.00	8860926.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79130000.00	79130000.00
210301	Гэрэл, цахилгаан	4800000.00	6267659.87
210302	Түлш, халаалт	69230000.00	69220800.00
210303	Цэвэр, бохир ус	5100000.00	3641540.13
2104	Хангамж, бараа материалын зардал	16830300.00	16830300.00
210401	Бичиг хэрэг	840000.00	1067300.00
210402	Тээвэр, шатахуун	13650000.00	13092004.84
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1820000.00	1830395.16
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	65300.00	133500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	455000.00	707100.00
2105	Нормативт зардал	29600000.00	29600000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	900000.00	807130.00
210502	Хоол, хүнс	28700000.00	28792870.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12810600.00	12810600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2400000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200000.00	89500.00
210604	Урсгал засвар	10210600.00	12721100.00
2107	Томилолт, зочны зардал	1240000.00	1240000.00
210702	Дотоод албан томилолт	1240000.00	1240000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4240800.00	4254582.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1960000.00	2200000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	683300.00	514088.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143000.00	143000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	954500.00	954500.00

«Audit_name» Булган аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210807	Газрын төлбөр	500000.00	442994.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1600000.00	1590432.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1100000.00	1097932.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500000.00	492500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1300000.00	1300000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	300000.00	300000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	300000.00	300000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1000000.00	1000000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1000000.00	1000000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	535611600.00	536321735.82
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	534401000.00	534871135.82
131001	Улсын төсвөөс санхүүжих	534401000.00	534871135.82
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1210600.00	1450600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1210600.00	1450600.00

«Audit_name» Булган аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит